



## Зөвт хүн алга гэж үү? (Туйлын ба харьцангуй үнэн)

Элч Петрт  
даатгагдсан  
“хозлуулагсдын  
төлөөх сайн мэдээ” ба  
Паулд даатгагдсан  
“хозлуулаагүй  
хүмүүсийн төлөөх  
сайн мэдээ” нь (Галат  
2:7) нэрээрээ ч өөр,  
агуулгаараа ч ялгаатай болох нь өмнөх хэдэн  
нийтлэлээс харагдсан. Хэмжээлшгүй хайр ивээлээр  
бялхах, “хозлуулаагүй хүмүүсийн төлөөх сайн  
мэдээ”-ний хосгүй агуулга нь хоёр үгээр: “Зөвтгөл” ба  
“Эвлэрэл”.



Энэ гайхалтай сайн мэдээ нь “итгэл сүсэггүй” (Г765)  
буюу Их Эзэнийг тоон хүндэтгэдэггүй, харин ч  
дээрэнгүй, дооглонгүй ханддаг хүмүүст хүртэл  
зориулсан! Тухайлбал: Христ “сүсэг бишрэлгүй...  
нүгэлтнүүд”-ийн төлөө” үхсэн! Загалмайн ачаар  
Ертөнцийн Эзэн тийм хүмүүсийг хүртэл зөвтгөдөг буюу  
цагаатгадаг (Ром 5:6,8)! Үүнд итгэсэн хүн хичнээн  
дорой нүгэлтэн байсан ч хамаагүй шууд л Ертөнцийн  
Эзэний хувьд буруутгахааргүй зөв хүнд тооцогддог  
болсон гэсэн үг. Учир нь: зөв “үйлс хийдэггүй” харин  
“сүсэг бишрэлгүй (Г765) хүнийг ч зөвтгөдөг” Түүнд  
итгэдэг хүний итгэл нь зөвт байдлаар тооцогддог (Ром  
4:5). Өөрийгөө гэмийн буруутгалаас салснаа мэдсэн  
итгэгч эрх чөлөөтэй болж, өөрийн талаас ч Ертөнцийн  
Эзэнтэй эвлэрэхэд хүрдэг (Ром 4:23-5:1).



Энэ бол үнэхээрийн шинэ сургаал. Петр, Иохан ба Есүсийн дүү Иаков нар Паулд өгөгдсөн сайн мэдээг Их Эзэнээс ирсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч (Галат 2:6-9) өөрснөө тэр сургаалыг зааж байгаагүй.

Харин ч Петр “Амийг хүсэмжилдэг нь... муугаас эргэж, сайныг үйлд... Учир нь Эзэний мэлмий зөвт хүмүүс дээр... Эзэний царай харин мууг үйлдэгчдийн эсрэг байдаг... Зөвт хүн арай гэж аврагдах юм бол, сүсэг бишрэлгүй (G765) нь болон нүгэлтэн нь яах болж байна?” гэж бичсэн (1 Петр 3:10-12; 4:18). Үүнд Есүсийн төрсөн дүү Иуда Енохын үгээр хариулж, Их Эзэн ирээд “бүх сүсэг бишрэлгүйчүүдийг (G765) сүсэг бишрэлгүй бус замаар үйлдсэн бүх сүсэг бишрэлгүй үйлсээр нь” шүүн шийтгэх болно. Энэ нь “сүсэг бишрэлгүй нүгэлтнүүдийн Түүний эсрэг ярьсан бүх хатуу үгсийг буруутгахын тулд” гэж бичив (Иуда 1:15).

| Петр, Иохан, Иаков, Иуда                                              | Паул                                                      |
|-----------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|
| Христ нүгэлтнүүдийг буруутгаж шийтгэх болно!                          | Христ нүгэлтнүүдийн төлөө үхсэн!                          |
| <i>Сайныг үйлд!<br/>Зөвийг үйлдэгч нь зөв.</i>                        | <i>Их Эзэн зөв үйлсгүй хүнийг зөвтгөдөг.</i>              |
| Их Эзэн сүсэг бишрэлгүй хүмүүсийг шүүн шийтгэнэ.                      | Их Эзэн сүсэг бишрэлгүй хүнийг зөвтгөдөг.                 |
| <i>Хүн зөвхөн итгэлээр бус, үйлсээр зөвтгөгддөг.<br/>(Иаков 2:24)</i> | <i>Үйлсгүй хүний итгэл зөвд тооцогддог.<br/>(Ром 4:5)</i> |
| Зөвт нь арай гэж аврагдана.                                           | Зөвтгөгдсөн бид тэр тусмаа аврагдах болно. (Ром 5:9)      |
| <i>Их Эзэний мэлмий зөвт хүмүүс дээр байдаг.</i>                      | <i>Зөвт хүн алга. Ганц ч алга.</i>                        |



Зөвт хүн алга гэж үү? • 3

Зөвт хүн байх тухайд Петрийн хамтрагч элч Иохан: “зөвийг үйлдэгч [=зөв үйлстэй] нь зөвт юм” гэжээ (1 Иохан 3:7).

Есүсийн төрсөн дүү Иаков үүнийг амьдралаараа үлгэрлэсэн. Чуулганы түүхч Евсебиусийн тэмдэглэсний дагуу Иаков байнга л Иерусалим дахь сүмийн өргөөнд орж өвдөг сөгдөн Их Эзэнээс ард түмнийхээ төлөө уучлал гуйдаг байсан учраас тэмээнийх шиг хатуу өвдөгтэй болсон бөгөөд иудей ард түмэн түүнийг “Зөвт Иаков” гэдэг байв.



Гэтэл Паул: “Зөвт хүн алга” гэж бичив (Ром 3:10). Тийм гэж үү? Библид олон зөвт хүн гардаг биз дээ? Абрахам, Иосеф, Мосе, Давид, Елиа, Даниел... эд нар бүгд “зөвийг үйлдэгч” зөвт хүмүүс байсан гэдэг. Ганц жишээгээр Иохан Баптистын эцэг эх хоёрыг дурдъя:

“Иудейн хаан Херодын өдрүүдэд Абиагийн бүлгийн Захариа нэртэй нэгэн тахилч байжээ. Түүний эхнэр ч бас Аароны удмаас гаралтай бөгөөд түүнийг Елизабет гэдэг байв. Тэд хоёул, Эзэний бүх тушаал зааврыг өөгүй дагаж, Бурханы өмнө зөвт байлаа.” (Лук 1:5-6)

Гэсэн хэдий ч: “Зөвт хүн алга. Ганц ч алга.” (Ром 3:10)



Дээрх хоёр ишлэл хоорондоо зөрчилдөж байна, тийм үү? Гэтэл Ертөнцийн Эзэний үг Үнэн учраас энэ хоёр ишлэл хоёулаа үнэн бөгөөд хоорондоо зөрчилдөхгүйг бид мэднэ. Зөрчилдөөн харагдсан үед бид нар л ямар нэгэн зүйлийг харгалзаагүйгээс болж буруу ойлгоод байна. Оюун ухаанд буй энэ зөрчилдөөнийг арилгахын тулд байдлыг хэрхэн зөв ойлгохыг энэ нийтлэлд авч үзнэ.

## **Оюун санаандаа гарсан зөрчилдөөнтэй тулах нь**

Хоёр эсрэг талыг барьсан бололтой дээрх хоёр ишлэл шиг өөр олон зөрүүтэй гэмээр ишлэл Бичвэрүүдэд бий. Эдгээрийг уншихад ихэнх итгэгч оюун ухаанд гарсан зөрчилдөөнийг үгүй болгохын тулд Их Эзэнээс мэргэн ухаан гуйж, Бичвэрүүдийг судлахын оронд нэг талыг нь зөвшөөрч, нөгөөг нь хайхралгүй өнгөрөөдөг.

“Хүн биеэ зөв авч явах ёстой” гэж бид ер нь багаасаа заалгасан учраас нэг талын зөвийг шууд олж хардаг. Нийгэмд ингэж заалгах нь мэдээж зөв. Эртний израилчууд мөн адил Ертөнцийн Эзэний Хуулийг дуулгавартай дагах ёстой гэж суралцдаг байв.

Христийн сүм цуглаанд хүртэл тэгэж номлох нь түгээмэл. Тийм номлолд үндсэндээ: “Есүст итгэдэг хүний хувьд та үгийг нь дуулгавартай дагах ёстой. Зөвт



**АМАР ХЯЛБАРЫГ НЬ  
СОНГОЖ БУС, ЗӨВИЙГ НЬ  
СОНГОЖ ХИЙ.**



хүн болохын тулд ингэх ёстой, тэгэх ёстой” гэж заадаг. Яагаад Библид зарим хүнийг “зөвт” гэдэг боловч бас “зөвт хүн алга” гэсэн үг хамт орсон байдаг вэ? гэж асуухаар ихэнхдээ “энэ бол хүн таахын аргагүй Мөнхийн Эзэний нууц” гээд мөрөө хавчин сэдвийг өөрчилнө.

Мөнхийн Эзэний олон нууц нь олж нээхийг хүссэн хүнд зориулж нуугдсан болохыг та мэдэх үү? Үүнд:

“Учрыг нууцлах нь Бурханы суу алдар.

Ухаж илрүүлэх нь хаадын суу алдар.”

(Сургаалт үгс 25:2)

Бид лав Ертөнцийн Эзэний Үгэнд хайхрамжгүйгээр хандахыг хүсэхгүй, учрыг нь олж бүх үгэнд нь итгэхийг хүснэ. Хүн зөвхөн мэдсэн зүйлдээ итгэж чадах учраас тэр. Тэгвэл ухах ажилдаа орцгооё!

### **Давид хаан: “Сайныг үйлддэг хүн алга”**

Юуны өмнө «Ром» захидалд буй Паулын үгийг үргэлжлүүлэн уншъя (Ром 3:10-12):

“Зөвт хүн алга.

Ганц ч алга.

Ухаардаг хүн алга.

Бурханыг хайдаг хүн алга.

Бүгд гажиж, цөмөөрөө хэрэгцээгүй болжээ.

Сайныг үйлддэг хүн алга. Бүр ганц ч алга.”





Үнэндээ Паул энд шинэ юм бичээгүй, харин «Хуучин гэрээ»-ний «Дуулал» номноос Давид хааны үгийг иштатсан. Үүнд:

“Сайныг үйлдэг хүн алга.

ИАВЭ тэнгэрээс хүн төрөлхтөнийг харлаа.

Бодож ухаардаг хүнийг эрлээ.

Бурханыг эрэлхийлдэг хүнийг хайлаа.


Тэд бүгдээрээ гажиж, бултаараа завхарчээ.

Тиймээс сайныг үйлддэг хүн алга, ганц ч алга.”

(Дуулал 14:1-3; бас 53:1-3-т давтсан байдаг)

Ингээд энэ чухал үг Бичвэрүүдэд гурвын гурван удаа бичигдэн батлагджээ.

“Хоёр юм уу, гурван гэрчийн амаар ямар ч үг батлагддаг” юм (2 Коринт 13:1; Матай 18:16; Дэд хууль 19:15 – бас л гурван гэрч...).



Гэтэл Захариа, Елизабет зэрэг хүмүүс яагаад “зөвт” гэгддэг вэ? Иохан Баптистын эцэг эх хоёр “Бурханы өмнө зөвт байсан” нь Их “Эзэний бүх тушаал зааврыг” буюу Мосегийн Хуулийг нягт нямбай мөрдөн дагаж, энэ тал дээр “өөгүй” байсныг хэлнэ. Улмаар тэд ихэнх үеийнхнээсээ ч илүү шударга зөв

амьдарсан нь эргэлзээгүй.

Гэтэл тэр хоёрыг Ертөнцийн Эзэний “өмнө” зөвт байсан гэсэн нь тэднийг Түүнтэй зэрэгцэн харьцуулаагүй нь мэдээж. Тэд Түүн шиг туйлын шударга зөв байсан гэсэн утга энэ үгэнд алга.



Зөвт хүн алга гэж үү? • 7

## Харьцангуй ба туйлын үнэн

Юм бүхнийг хоёр өнцгөөс авч үзэж болдог: хүний өнцгөөс эсвэл Бүтээгч Эзэний өнцгөөс.

Аливаа байдлыг хязгаарлагдмал бидний өнцгөөс харахад дутуу харагдах нь аргагүй. Дутуу байсан зарим зүйлийг олж нэмэхээр тэс өөр харагдаж болно. Ер нь, хүн юмыг өөр юмтай харьцуулан байж л ойлгон авч чаддаг. Тиймээс хүний олж хардаг зүйлд нь харьцангуй л үнэн байдаг.

Харин эн хязгааргүй Бүтээгч Эзэн Өөрийн өнцгөөсөө бүгдийг яг байгаагаар нь хардаг. Бүтээгч Эзэний “тэнгэрээс харсан” хараа (Дуулал 14:2) туйлын үнэнийг илчилдэг.

Библи уншихад энэ хоёр өнцгөөс харсан хараа хоёулаа тааралддаг, харьцангуй ба туйлын үнэн хоёулаа гардаг. Ертөнцийн Эзэн биднийг өршөөн үзэж,

Өөрийгөө бидэнд ойлгуулахын тулд харьцангуй үнэний түвшинд маань бууж хүний өнцгөөс юм хэлэх нь олонтаа. Бас Өөрийнх нь жишиг болох туйлын үнэн юу болохыг ч бидэнд мэдүүлнэ.


Тийм учраас бид тэр хоёр өнцгөөс харсан харааг ялгаж, туйлын үнэнийг харьцангуй үнэнээс салгаж сурах нь зүйтэй.





Ертөнцийн Эзэн бол Сүнс учраас хаа сайгүй оршдог. Түүний хаана байдгийг тогтоож, тодорхойлж болдоггүй гэсэн үг. Үүнийг хүн бид төсөөлж чаддаггүй. Тэгэхлээр “Түүний өмнө” гэсэн хэллэг Ертөнцийн Эзэнийг нэг ёсондоо байрлалтай болгосон. Энэ нь хүн бидний өнцгөөс харсан харьцангуй үнэнээс гарсан хэллэг юм.<sup>1</sup>

Захариа Елизабет хоёрыг “Бурханы өмнө зөвт” гэж хэлсэн нь туйлын биш, харьцангуй үнэнийг хэлсэн гэсэн үг. Хүний нүдээр харахад, мөн бусадтай харьцуулахаар тэр хоёр харьцангуй зөвт хүмүүс байлаа. Тэд үнэхээр Хуулийн бүх тушаал, зааврыг биелүүлэхийг уйгагүй хичээдэг. Тэд үеийнхнээсээ илүү Ертөнцийн Эзэний ард түмэнд нь захисан үгийг дагахад анхаардаг байв. Тэр хоёр шиг Их Эзэний өөрт нь хэлснийг зөв дагаж явдаг хүнийг харахдаа “зөвт байх” гэж чухам юу хэлдгийг бид ойлгож эхэлдэг.



---

1 Үүнчлэн олон үзэгдэлд Ертөнцийн Эзэн сэнтийд заларсан нь үйл явдлыг бидэнд ойлгогдох байдлаар харуулсан байна. Үнэн хэрэгтээ Ертөнцийн Эзэн хаана нэг газарт суудаггүй, Түүнийг төлөөлөгч баруун гар нь болсон Христ тэнгэрийн улсын сэнтий дээр залардаг.



Үүний бас нэгэн жишээ бол Ноа. Ноад Их Эзэн хандан, “энэ үеийнхний дотроос чи Миний өмнө зөвт байгааг Би харсан” гэжээ (Эхлэл 7:1). Ноаг Их Эзэн үеийнхэнтэй нь харьцуулсан, Өөрийнхөө өмнө байрлуулсан мэт ярьсныг анзаарна уу!

Гэхдээ энэ хүмүүсийн “харьцангуй зөвт байдал” Ертөнцийн Эзэний зөв шударга байдалд тэнцэхгүй нь мэдээж. Хүний зөвт байдал дэнлүү шиг гэрэлтдэг бол Бүтээгч Эзэнийх үдийн наран шиг. Тоос шороогоор бүрдсэн хүн хэрхэн Түүн шиг төгс ариун, Түүн шиг туйлын зөвт байх вэ!

Захариа Елизабет хоёр үүнийг сайн мэддэг байсан нь Аврагч Хааны тухай Захариагийн үгнээс харагдана: “...Дорнын гэгээ бидэн рүү дээрээс айлчлан ирэх нь Харанхуй хийгээд үхлийн сүүдэрт суугсдын дээр гийж, Хөлийг маань амар тайвны замд чиглүүлэхийн тулд юм” гэв (Лук 1:78-79). Тэр “дорнын гэгээ” бол Ертөнцийн Эзэний мандуулахаар амласан “зөв шударгын нар нь” болох Есүс Их Эзэн (Малахи 4:2; Иохан 8:12). Түүний бас нэг нэр нь “ИАВЭ бол бидний зөвт байдал” (Иеремиа 23:6; 33:16). Үүнээс дүгнэхэд Захариа 14-р дууллын үгийг хүлээн зөвшөөрч, бүгд үхлийн харанхуйд суудаг учраас Ертөнцийн Эзэнгүйгээр сайныг үйлдэж чадахгүй гэдэгт итгэдэг байсан.

Захариа Елизабет хоёрыг “зөвт” гэж дүгнэснийг тайлбарлах ганц арга бий. Тэдэнд Бүтээгч Эзэн Өөрөө Өөрийг нь эрэлхийлэх хүслийг ч хайрлаж, сайныг үйлдэх хүчийг ч өгсөн. Ямар ч сайн сайхан зүйл Бүтээгч Эзэнээс ирдэг юм (Иаков 1:17).



## Өөрийн зөвт байдлаа тогтоохыг эрмэлзэх нь

Хүн өөрөө өөрийн хүчээр үнэн зөв байж чадахгүйг ихэнх хүмүүс харин хардаггүй. Сайн хүн байхын тулд хүн өөрөө зөв юм хийхийг сонгон, шийдсэнээ өөрөө биелүүлэх ёстой. Энэ нь дур зоригийн эрх чөлөөг шаардах бололтой учраас хүн зөв явах эсэхээ өөрөө л шийддэг гэсэн дүгнэлт түгээмэл. Алдаа нь яг үүнд оршино: “Хүн өөрөө” гэдэг нь Бүтээгч Эзэнээсээ бие даасан байдлаар өөрөө зүтгэхийг хэлнэ. Гэтэл хүн Бүтээгч Эзэнээсээ бие даах нь угийн боломжгүй хэрэг. Зөв явах тал дээр Бүтээгч Эзэнээсээ зууралдахгүй бол бүр ч бүтэхгүй хэрэг. Үүнээс гадна, “би өөрөө” гэсэн зүтгэлтэй хүн Бүтээгч Эзэний биш, өөрийн зөвт байдлаа хорвоогийн хэмжүүр болгодог.

Есүст итгэхээсээ өмнө Паул өөрөө зүтгэн байж зөвт байдлаа тогтоохыг эрмэлздэг байв. Олон иудейчүүд яг ийм зүтгэлтэй. Тэд нарны гэрлийг мэдэхгүй, харанхуйд асаасан дэнлүүгээ хорвоогийн гэрэл гэж боддог мэт. Тэдний тухай бичихдээ Паул өөрийгөө ч эргэн санасан биз ээ. Тухайлбал:

“Тэд Бурханы төлөө хичээл зүтгэлтэй боловч, энэ нь мэдлэгийн дагуу биш гэж би тэднийг гэрчилдэг. Тэд Бурханы зөвт байдлыг мэдэлгүй, өөрсдийнхийгөө тогтоохыг эрмэлзэж, Бурханы зөвт байдалд захирагдаагүй юм.” (Ром 10:2-3)





Паул урьд нь Захариа Елизабет хоёр шиг “хууль дахь зөвт байдлаар өө сэвгүй” болоод байсан (Филиппой 3:6). Гэвч 14-р дууллыг мэдсэн ч Паул урьд нь яагаад ч юм өөрийгөө тэр ишлэлд дурдсан хүмүүсийн тоонд оруулаагүй. Бүтээгч Эзэнээ эрэлхийлдэггүй, сайныг үйлддэггүй хүмүүсийн бүлгээс өөрийгөө мултарч чадсан гэж үзэв. Биеэ тоосон энэ сэхүүн байдал нь өөрийгөө бусдаас дээр, Бүтээгч Эзэнийхээ хувьд ч буруутахааргүй зөвт хүн гэж тооход хүргэв. Гэвч хүний тогтоодог өөрийнх нь зөвт байдал хэзээ ч Бүтээгч Эзэнийхэд хүрдэггүй. Дэнлүүний гэрэл үдийн наранд харагдах ч үгүй. Үүнийг ойлгоогүй хүн Бүтээгч Эзэний зөвт байдлыг огт мэдэхгүй бөгөөд 14-р дууллын үгийг хүлээн зөвшөөрдөггүй.

Харин Их Эзэн Өөрийн хүртээх зөвт байдлыг илчилсэн сайн мэдээг (Ром 1:17) зарлахаар яг тэр биеэ тоосон, сэхүүн залууг барьж авсан юм. Христ Есүс “тэнгэрийг яраад” бууж ирэхдээ “Би бол чиний хавчиж мөшгөөд байгаа Есүс байна” гэж алдар нэрээ өстөн дайсандаа мэдүүлэхэд тэрний хувьд хамаг ертөнц нь доргин орвонгоор нь эргэчихсэн биз ээ. Тэр мөчид Паулын өөртөө тогтоож байсан зөвт байдал нь юу ч үгүй болтол сарнижээ.





“Бүгдээрээ бид бузар болжээ, бүхий л сайн үйлс маань бохирдсон бөс мэт ажээ. Навч шиг л бид цөмөөрөө хорчийжээ. Нүгэл маань биднийг салхи шиг хийсгэжээ...”

Харин ИАВЭ минь Та бидний Эцэг. Бид бол шавар, Та бидний ваарчин. Бүгдээрээ бид Таны мутрын бүтээл” гэсэн зөгнөлийн үг тэр үед Паулын санаанд буусан байж магад (Исаиа 64:1-6; Үйлс 9:1-6).

Ямар ч байсан 14-р дууллын үгийн үнэн түүнд үдийн наран шиг тод болжээ. «Ром» захидлын 3-р бүлэгтээ тэр үгийг эш татаад онцгойлон Ертөнцийн Эзэний хуулийн дор буй хүмүүст хэлсэн болохыг нь анхааруулсан. Тэр хүмүүсийн дундаас шинэ Паул юуны өмнө өөрийгөө буюу хуучин амьдралаа бодсон биз ээ. Үүнд:

**“Хуулийн хэлж байгаа болгон нь хуулийн дор байгсдад хандан ярьдгийг бид мэддэг. Ингэснээр ам болгон таглагдаж, ертөнц даяараа Бурханы өмнө буруутгагдах болно. Учир нь ямар ч махбод хуулийн үйлсээр Түүний өмнө зөвтгөгдөхгүй. Хууль нь нүглийг мэдүүлэгч л юм.” (Ром 3:19-20)**

Их Эзэний хийсэнд түшихгүй, өөрийнхөө үйлдсэн “...хуулийн үйлсийг түшигчид бүгдээрээ хараал доор байдаг. Учир нь "Хуулийн номд бичигдсэн бүхнийг хэрэгжүүлдэггүй, дагадаггүй хүн бүр хараагдсан" гэж бичигджээ” (Галат 3:10). Хуулийг нэг ч алдахгүйгээр төгс төгөлдөр дагах нь хүний хувьд боломжгүй



учраас “ямар ч махбод” (сул дорой хүн) хэзээ ч дан Хуулийн дагуу амьдарснаар Ертөнцийн Эзэний өмнө зөвтгөгдөнө гэж байхгүйг Паул ухаарчээ.

Яг үүнийг Есүс нэгэн сургаалт үлгэрээрээ хэлсэн. Сүмийн өргөөнд залбирахдаа өөрийн зөвт байдлаа Ертөнцийн Эзэний өөдөөс гайхуулсан фарисай хүн зөвтгөгдөөгүй, харин гэмт байдлаа ухамсарлан өөрийгөө Их Эзэний хайр энэрэлд даатгасан татвар хураагч “зөвтгөгдөн гэртээ харив” (Лук 18:10-14).<sup>2</sup>



Тэгвэл Их Эзэн Хуулийг чухам яах гэж өгсөн бэ гэхэд Паул Хууль өгөгдсөний учир гэм нүгэл юу болохыг мэдүүлэхэд оршино гэсэн.

- 2 “Нүгэлт намайг өршөөгөөч” гэж хэлсэн татвар хураагчийн үгийг бүр нарийн орчуулбал “нүгэлт надад эвлэрүүдэл хийгээд өгөөч” гэсэн утгатай (Еврей 2:17-т адилхан үг орсон; G2433). Эвлэрүүдэл Мосегийн Хуульд заасан малын тахилаар хийгддэг байв (Левит 4:27-31). Сайх татвар хураагч Ертөнцийн Эзэний Хуулийн утгыг ойлгож, тэр Хуулийн хэмжээнд зөвтгөгдсөн. Гэтэл үнэн хэрэгтээ “бух, ямааны цусаар нүглийг авч хаях боломжгүй юм” (Еврей 10:4). Тийм учраас Ертөнцийн Эзэн Есүсийг үнэн эвлэрүүдэл болгосон юм (Ром 3:25, G2435).



## “Харин эдүгээ Бурхан...”

«Ром» захидлын 3-р бүлгийг цааш уншихад:

**Харин эдүгээ Бурханы зөв нь хуулиас ангид илчлэгдэв. Үүнийг Хууль ба Эш үзүүлэгчид гэрчилсэн юм.**

**[Есүс Христийн итгэлээр] Бурханы зөв нь [бүгдийн төлөө бөгөөд итгэгч бүхний дээр] байна. Ялгаварлал байхгүй. Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй авч Христ Есүсийн золилтоор дамжин Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгдөнө.”**  
(Ром 3:21-24, [ийм хаалтан доторх үгийг грек эхийн дагуу засав])

“Харин эдүгээ” гэдэг үг маш чухал. Паулыг анх тусгаарлан илгээснээс эхлэн (Үйлс 13) Их Эзэн цоо шинэ юм хийлээ! Түүний хардаг зөв шударга нь хуультай буюу зөв үйлс хийхтэй ямар ч холбоогүй боллоо. Хүн хичнээн зүтгэсэн ч Ертөнцийн Эзэний зөв байдалд хэзээ ч хүрч чадахгүй учраас тэр.



Есүс Христийн Загалмай дээр харуулсан итгэлийн хариуд Ертөнцийн Эзэн Өөрийн зөвт байдлаа хүнд “үнэгүй”-гээр (үйлс хийсний хариуд биш) хүртээдэг болсон.



Энэ бол нөгөө “Ертөнцийн Эзэний өмнө” байрласан, харьцангуй зөвт байдлыг хэлээгүй шүү, харин Бүтээгч Эзэний Өөрийнх нь туйлын зөв шударгыг хэлсэн! Энэхүү зөвт байдлыг Тэрээр цэвэр хайр ивээлээр өгдөг болсон! Энэ зөвт байдал нь нүгэл үйлдсэн бүх хүнд бэлдсэн байгаа ч (“бүгдийн төлөө”), одоогийн байдлаар Есүс Христийн хийсэн үйлсэд итгэсэн хүн бүрийн дээр байна.

### **Хууль ба эш үзүүлэгчдийн дундаас хоёр гэрч**

Энэхүү шударга зөв байдлыг “Хууль ба Эш үзүүлэгчид гэрчилсэн юм”. Гэрчилсэн нэг эш үзүүлэгчийг дурдахад, Хабаккук: “Зөвт хүн итгэлээр амьдарна” гэж бичсэн (Хабаккук 2:4, Ром 1:17). Үүний дагуу, “Бурханы хүртээх зөвт байдал нь сайн мэдээний дотор [Христийн] итгэлээс [хүний, бэлгээр авсан] итгэлд илчлэгддэг” (Ром 1:17, [нэмсэн тайлбар]).

“Зөвт Нэгэн” болох Есүс Аавдаа итгэсэн бөгөөд Аав нь Түүнийг үхэгсдээс амилуулсан. Түүнд итгэх итгэлийг хүлээж авсан бид Ертөнцийн Эзэний зөвт байдлыг хүртсэн бөгөөд үхсэн ч дахин амилах болно.

“Хууль”-ийн номд «Эхлэл»-ээс «Дэд хууль» хүртэлх Библийн эхний таван ном хамрагддаг. Тэгвэл «Эхлэл» номд Ертөнцийн Эзэний зөв шударгын тухай үнэнг гэрчлэх нэг хүнийг дурдахад: Абрахам. “Абрахам, Бурханд итгэсэн. Үүгээр нь түүнийг зөвд тооцсон” гэдэг (Ром 4:3-22).



Тухайн үед Абрахам өндөр настай ч нэг ч хүүхэдгүй байхад Ертөнцийн Эзэн түүнийг олон үндэстний эцэг болгож, түүгээр энэ газар дэлхийн бүх овгийг ерөөх болно гэж амлажээ. Абрахам өөрийн махбодоо хараад “үхширсэн” буюу эцэг болох ямар ч найдваргүй болсныг нь мэдэж, бас эхнэрийнхээ умай ч “үхмэл” болсныг сайн мэдсэн ч гэсэн Ертөнцийн Их Эзэн амласнаа биелүүлж чадна гэдэгт бүрэн

итгэлтэй

байсан.

Абрахамын

итгэл Их

Эзэнийг

алдаршуулсан

учраас Их

Эзэн

Абрахамыг

таалан үзэж

зөвд тооцсон

(Эхлэл 12:3,

15:1-6).



Энэ үнэлгээ Абрахамыг хозлуулаагүй (хөвч хөндүүлээгүй) байхад хийгдсэн. Тиймээс энэ үг хозлуулаагүй үндэстнээс гаралтай бидний төлөө ч бичигдсэн юм (Ром 4:10,23). Бид Абрахам шиг өөрийн “нүглийн махбодоо” ч, хажууд буй хүнээ ч хараад Ертөнцийн Эзэн шиг шударга зөв болох ямар ч найдваргүй улсууд болохоо хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.



Тийм байсан ч Их Эзэн хүүхэдгүй Абрахамыг “олон үндэстний эцэг” гэж дуудсан шиг биднийг одоо ч “зөвт” гэж дууддаг бөгөөд хожим Абрахамыг үнэхээр олон үндэстний эцэг болгосон шиг биднийг ч үнэхээр хожим Өөрийн шигээ зөвт болгоно гэж амласан Ертөнцийн Их Эзэнд бид итгэнэ. Бид хамаг найдвараа өөртөө биш, Христэд тавьсан гэсэн үг. Үйлсгүй байлаа ч, “сүсэг бишрэлгүй хүнийг зөвтгөдөг Түүнд итгэдэг хүний итгэл нь зөвд тооцогддог” гэж хэлсэн Түүний үгэнд бид итгэлээ (Ром 4:5).

## Туйлын үнэнг тунхагласан сайн мэдээ

“Захариа... Елизабет... хоёул, Эзэний бүх тушаал зааврыг өөгүй дагаж, Бурханы өмнө зөвт байлаа.” Гэсэн ч: “Зөвт хүн алга. Ганц ч алга.”

Дээрх хоёр ишлэл хоёр өнцгөөс хэлсэн болохыг ойлговол чихэнд зөрчилдөхөө болино. Хэн нэгэн хүн “Бурханы өмнө зөвт байсан” тухай үг хүний өнцгөөс харсан харьцангуй зөв байдлыг хэлнэ. Харин “зөвт хүн алга” гэсэн туйлын үнэн Ертөнцийн Эзэний өнцгөөс харагддаг:



Ертөнцийн Эзэний жишгээр хэмжихид хамгийн сайн хүн хүртэл дутуу. Үүнийг ойлгохоор бид харьцангуй чанарт бодит байдалд маань нийцэхгүй юм шиг Түүний харсан үнэнг хүлээн авч чадахад хүрч, тэр хоёр ишлэлийн аль алинд нь бүх зүрх сэтгэл, хамаг оюун ухаанаар итгэх чадвартай болно.



Дүгнэж хэлэхэд, Паулд даатгасан сайн мэдээгээр Ертөнцийн Эзэн туйлын зөвт байдлаа хүнд бэлэг болгон хүртээдэг болсноо илчилсэн. Уг сайн мэдээнд Ертөнцийн Эзэн Өөрийн үзлээ хамгийн ихээр харуулдаг. Петрийн зарласан сайн мэдээ нь ерөнхийд нь харьцангуй үнэнг хардаг хүний түвшинд тааруулсан бол Паулын сайн мэдээ нь хүнд харагдснаас илүү өндөр түвшний, илүү өргөн хүрээтэй, туйлын үнэний тухай гэж хэлж болно.

Тийм учраас Паулын 13 захидалд хүн төрөлхтөний түүх товчхон ч гэсэн эхнээс нь төгсгөл хүртэл гардаг. Петрийн сайн мэдээ нь Израилын өвөг дээдэс болох Абрахам, Израилын хамгийн алдарт хаан болох Давид нарт амласан амлалтууд нь хэрхэн 1000 жилийн Хаант улсаар биелэгдэх тухай. Тийм учраас энэ нь ганц тэр үндэстэнд хандсан билээ (Матай 1:1; 3:2). Петрийн сайн мэдээ бол “Ертөнцийн Эзэний өмнө” буюу Түүний хараанд зөв амьдрах тухай. Харин Паулын сайн мэдээ бол “Ертөнцийн Эзэний дэргэд” зөвд тооцогдох тухай.<sup>3</sup> Паулын сайн мэдээ нь Адамын анх бий болгосон асуудал шийдэгдсэн тухай. Иймд Паул хамаг хүн төрөлхтөнийг Адамаас эхлэн эон үеүдийн төгсгөл хүртэл нэгмөсөн авч үзнэ (1 Коринт 15:22-28). Тэгэхдээ Ертөнцийн Эзэний туйлын зорилгыг илчиллээ: “бүгдэд бүх юм болох” явдал юм.

---

3 Грек хэлээр “өмнө” (G1799) гэдэг үг үгчлэн “хараанд” буюу “нүдний өмнө, нүдэн дээр” гэсэн утгатай. Харин Ром 2:13-д “Бурханы өмнө (G3844) зөвтгөгдөх” тухай гарахад АБ бас “өмнө” гэж орчуулсан ч, грекээр “хажууд, ойрхон, дэргэд, хамт, хувьд” гэсэн утгатай өөр үг бичсэн байна (G3844).



Хэдийгээр хүмүүсийн дунд зарим нь сайн хүн, зарим нь “зөвт хүн”, өөр зарим нь сайн үйлсгүй, “нүгэлтэн”, “бурханлаг бус”, “сүсэг бишрэлгүй”, “буруутан”, муу хүн боловч Ертөнцийн Эзэн шиг шулуун шударга, үнэн зөв хүн Адамаас гаралтай хүн төрөлхтөнд алга. Энэ тал дээр хүн засагдахааргүй байна.

Тийм ч учраас Бүтээгч Эзэн хүн төрөлхтөнийг Загалмай дээр нэг ёсондоо үндсээр нь сугалан авч, шинээр бүтээх болсон. Шинэ бүтээлд “зөвт байдал оршдог” (2 Петр 3:13). Энэ замаар Их Эзэн хүн болгоныг “үнэгүй зөвтгөж”, Өөрийн зөвт байдлаа хүртээх болно (Ром 3:24). Гэхдээ “тус бүр өөрийн дараалалтай” буюу ээлжтэй юм (1 Коринт 15:23)!

Өнөөдөр энэ сайхан мэдээнд итгэсэн хүмүүс өнөөдөр ч Их Эзэний хувьд зөвт хүмүүс юм. Тэр биднийг Өөртэйгээ хамт байж, дотно нөхөрлөхөөр ямар ч асуудалгүй тооцдог гэсэн үг.

Тэгсэн ч гэсэн бид мэдээж бусад бүх хүний адил “Ертөнцийн Эзэний өмнө” амьдарч байна (Ром 14:22; 2 Коринт 4:2; 1 Тимот 5:4,21 г.м.). Бид туйлын үнэнийг мэдэж авсан ч гэсэн энэ дэлхийд байх цагтаа хүний



харьцангуй түвшинд амьдрахаас өөр аргагүй. Энэ хоёр харааны хооронд амьдрахад итгэл хэрэгтэй. Энэ итгэлийг бидэнд Өөрийнх нь тогтоосон хэмжээгээр оноосон Их Эзэнд талархъя (Ром 12:3)!



*“Хүн үйлсээрээ зөвтгөгддөг” гэж хэлсэн элч Иаковын үгийг Паул харин эсэргүүцэх мэтээр: “Үгүй, бид үйлсээрээ биш, дан итгэлээр зөвтгөгддөг” гэж бичсэн. Олон зууны турш теологичдийг маргалдахад хүргэсэн эдгээр зөрчилдөх үгийг дараагийн нийтлэлд авч үзнэ.*

#### Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Eusebius (ca. 339). *Ecclesiastical History*, Book II, Ch. XXIII

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). [www.blueletterbible.org](http://www.blueletterbible.org)